



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ¹

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж заажээ.

Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтлана” гэж, 5.3.4-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Арбитрын тухай хуулийг шинэчлэн, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Үүний дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалт нь Үндсэн хууль болон дээрх үйл ажиллагааны хөтөлбөрт нийцэж байгаа эсэхийг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тус хүрээлэн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу уг үнэлгээг хийв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх энэхүү үнэлгээний зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ИХШХШТХ гэх/ хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөх үе шатанд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

¹ Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, У.Эрдэнэзаяа нар хамтран гүйцэтгэв.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Бид өдөр тутмын амьдралдаа хамгийн түгээмэл байдлаар иргэний эрх зүйн харилцаанд оролцдог. Тиймээс ч нийгэмд үүсч буй маргааны дийлэнх хувийг иргэний эрх зүйн маргаан эзэлдэг.

Түүнчлэн, дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгэм, технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор иргэдийн хооронд үүсч буй эрх зүйн харилцааны төрөл нэмэгдэж байгаа нь эрх зүйн маргааныг улам төвөгтэй, нийгмийн олон талт харилцааг хамарсан шинжтэй болгож байна.²

Ийнхүү иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхийн тулд талуудын эрхийг хангах, хамгаалах зайлшгүй шаардлагатай тулгардаг бөгөөд иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалж, хангах шүүхийн үйл ажиллагааны нэгэн төрөл нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа юм. Энэ нь иргэд, хуулийн этгээд шүүхэд хандаж, нэхэмжлэл, өргөдөл, хүсэлт гаргах, шүүгч нэхэмжлэл, өргөдөл хүсэлтийн шаардлагыг хангах, захирамж гарган иргэний хэрэг үүсгэх, иргэний хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх, анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын гомдол гаргах, эдгээр гомдлыг зохих шатны шүүхээр хянан хэлэлцэж магадлал, тогтоол гаргах, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэх мэт хуульд заасан олон төрлийн үйл ажиллагаатай холбоотой.³

Монгол Улс ИХШХШТХ-ийг 2002 оноос дагаж мөрдөж эхэлснээс хойш арван зургаан жилийг ардаа үүдээд байна. Энэ хугацаанд ИХШХШТХ-ийн алдаа дутагдал, эрх зүйн хийдлийг арилгахтай холбоотой хэд хэдэн удаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг хуулийн практикт хэрэгжихэд хүндрэлтэй заалт, түүнийг хэрхэн засаж сайжруулах талаар эрдэмтэн, судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр ирсэн билээ.

Өөрөөр хэлбэл, ИХШХШТХ нь харьцангуй тогтвортой үйлчилж ирсэн боловч хуулийн зарим бүлгүүд хоорондоо логик уялдаа холбоо муутай, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн тулгуур ба тусгай зарчмууд бүрэн хэмжээгээр тусгагдаж чадаагүй, хуулийн зарим зохицуулалтууд тодорхой бус зэргээс болж зарим талаар хэрэглэхэд хүндрэл учирч шүүхийн шийдвэр өөрчлөгдөж, хүчингүй болоход нөлөөлж байна.⁴

Тухайлбал, ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” хэмээн заасан нь практикт ажиллаж буй шүүгч, өмгөөлөгч болон тус салбарын эрдэмтэн, судлаачдын дунд өнөөдрийг хүртэл маргаан дагуулсаар байна. Иймд хуулийн дээрх заалтыг өмгөөлөгч, шүүгчид хэрхэн ойлгож, хэрэглэдэг цаашлаад уг зохицуулалтын хэрэгжилтийг судлан, үүсэн бий болсон асуудлыг хэрхэн шийдвэрлэх гарц, гаргалгааг олохын тул энэхүү зохицуулалтыг судлах зайлшгүй шаардлага бий болсон хэмээн үзэж байна.

Мөн тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” зохицуулалт нь өнөөдрийг хүртэл практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээлийг бий болгосоор байгаа билээ. Иймд энэхүү үнэлгээгээр дээрх дурдсан зохицуулалтуудын хэрэгжилтийг үнэлэх болно.

² 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт илтгэсэн УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч Г.Цагаанцоожын илтгэлээс.

³ 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлгийн тэмдэглэлээс.

⁴ Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай, Хууль дээдлэх ёс сэтгүүл, №2, 2016 он, 68 дахь тал.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Иймд хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож, үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байдаг.

ИХШХШТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлэх 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай заалт болон тус хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалтын эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ИХШХШТХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ИХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлжээ.

Энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилтыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтын нэг болох ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан заалтыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг	31.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.
2	166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэг	166.4.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай заалт, мөн тус хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянах тухай зохицуулалтууд нь практикт нэлээд маргаан дагуулдаг заалтууд юм.

Судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт болон давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт нь төрийн эрх ашиг зөрчигдсөн хэмээх ойлголтыг хууль болоод УДШ-ийн 263 дугаар тогтоолоор хангалттай тодорхой, ойлгомжтой байдлаар тайлбарлаагүйгээс прокуроруудын дунд энэхүү ойлголтыг хэрхэн авч үзэх нь өнөөдрийг хүртэл эргэлзээтэй байдлыг бий болгосоор байна.

ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан “давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх” тухай зохицуулалт нь практикт хэд хэдэн асуудлыг дагуулж байна. Тухайлбал, хуульд заасан дээрх үндэслэлийг хангахын тулд давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэж, хэргийг буцааж буй нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахад хүргэж байгаа нь ажиглагдаж байна.

Иймд ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон мөн хуулийн 166 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалтыг сонгон судалсан болно.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг	31.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.
2	166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэг	166.4.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад дээрх харьцуулах хэлбэрээс ИХШХШТХ-ийн сонгон авсан зохицуулалтыг хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг судлан үзнэ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолоходоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр ИХШХШТХ-ийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл уншиж, судлах, харьцуулалт хийх, шүүгч, прокурор, өмгөөлөгч, судлаачидтай уулзаж ярилцлагын судалгааны аргаар санал авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос байгаа мэдээллийг цуглуулж ашиглах, холбогдох субъектээс судалгаа авах гэсэн хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ИХШХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, шүүгч, прокурор, өмгөөлөгч, судлаачдаас ярилцлага авч энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: ИХШХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;

Прокурорын байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №29;

Прокурорын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №24;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996, №11;

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, УДШ-ийн 2002 оны 7 сарын 24-ний өдрийн 236 дугаар тогтоол;

УДШ-ийн 2009 оны 11 сарын 30-ны өдрийн 5 дугаар зөвлөмж, Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар;

Улсын Ерөнхий Прокурорын 2015 оны А/88 тоот дугаар тушаалаар батлагдсан Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар;

Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны А/62 тоот дугаар тушаалаар батлагдсан Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар.

Судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол Улсын шүүхийн тайлан /2017 он/, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он;

Ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл

Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд, 2013 он;

З.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, 2009 он;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, МУИС-ХЗС, 2011 он;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УДШ, 2007 он;

Юпп Ёоахимски, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, 2004 он;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /гарын авлага/, ХЗДХЯ, 2007 он;

Тушаал, заавар, журмын эмхэтгэл, УЕПГ, 2017 он;

Хууль дээдлэх ёс сэтгүүл, ХЗҮХ, 2016 он, №2;

Шүүх эрх мэдэл сэтгүүл, ШЕЗ, 2017 он, №3;

Монголын төр, эрх зүй сэтгүүл, УДШ, 2014 он, №2 (76);

Монголын төр, эрх зүй сэтгүүл, УДШ, 2018 он, №2 (91);

Эрх зүй сэтгүүл, МУИС-ХЗС, 2003 он, №10-11;

Эрх зүй сэтгүүл, МУИС-ХЗС, 2014 он, №4 (30).

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /Гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

Холбогдох субъектээс авсан судалгаа

Ярилцлагын арга: ИХШХШТХ-ийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар шүүгч, прокурор, өмгөөлөгч, судлаачдын төлөөлөлтэй ярилцлага хийсэн.

Судалгааны анхдагч мэдээллийг ярилцлагын аргаар практикт ажиллаж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч, судлаачдаас авсан тул илүү бодитой, үр дүнтэй байдлыг хангаж чадна гэж үзсэн болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйл болон мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан заалтад сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ИХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

31.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.

Үнэлгээ:

ИХШХШТХ батлагдсан эхний үеүүдэд төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор дийлэнх тохиолдолд оролцож эхэлсэн бөгөөд хуулийн нарийвчилсан зохицуулалт дутуу, хуулийг тайлбарласан УДШ-ийн тайлбар нь хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилтэйгээс сүүлийн жилүүдэд иргэний эрх зүйн маргаанд прокурор оролцох нь харьцангуй багассан.⁵

Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай зохицуулалт нь 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан онцлог зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, хуулийн үзэл баримтлал, уг зохицуулалтыг хуульчлах болсон тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн шалтгаан зэргийг дурдалгүй өнгөрч болохгүй.

Тухайн үед төрийн байгууллага иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо ихэнх маргаанд ялагддаг, тусгайлан өмгөөлөгч авах хөрөнгө санхүүгийн бололцоогүйгээс мэргэшсэн мэтгэлцэгч тал болох өмгөөлөгчтэй мэтгэлцэж чаддаггүй, иймээс өөрт ашигтай шийдвэр гаргуулдаггүй гэсэн дүгнэлтэд хүрч байсан бөгөөд энэхүү мэргэжлийн мэтгэлцэгчтэй адил байж төрийг төлөөлөн мэтгэлцэж чадах субъект бол прокурор юм гэсэн үзэл баримтлал энэ үеэс бий болсон байна. Энэ тохиолдолд мэргэжлийн хуульч болох прокурор нь төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцдог субъект болохын хувьд төрийг үнэ төлбөргүйгээр өмгөөлөх боломжтой гэсэн үзэл баримтлалаар энэхүү зохицуулалт хуульд тусгалаа олсон

⁵ 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэг “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлээс.

байдаг.⁶

Өөрөөр хэлбэл, ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалтыг хуульчлах болсон зорилго нь төрийн ашиг сонирхол зөрчигдөхөд төрийн зөрчигдсөн ашиг сонирхол, эрхийг хамгаалах этгээд тодорхойгүй байсныг зохицуулах зайлшгүй шаардлага бий болсонтой холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Энэхүү зохицуулалт хуульчлагдсанаар ИХШХШТХ-д зааснаар прокурор иргэний хэрэгт зохигчоор оролцох, эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг бий болгосон юм. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл практикт төрийн ашиг сонирхол зөрчигдсөн иргэний хэрэг бүрт прокурор зохигч болон оролцдоггүй. Зарим тохиолдолд төрийн байгууллага прокурорыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах хүсэлт гаргасан хэдий ч прокурор тухайн хүсэлтэд дурдсан үндэслэл нь төрийн ашиг сонирхолд зөрчигдсөн гэж үзэх үндэслэлд хамаарахгүй байна гэсэн үндэслэлээр иргэний хэрэгт оролцохоос татгалздаг байна.

Энэ нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэх ойлголтыг тодорхой байдлаар тайлбарлаагүй, хуулийн зохицуулалт, хуулийг тайлбарласан УДШ-ийн тайлбар нь хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилдсөнтэй холбоотой хэмээн прокурорууд тайлбарлаж байна.

Түүнчлэн, практикт прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдол одоо ч гольдролдоо ороогүй, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй ерөнхий байдлаар хэрэгжсээр байна. Дээрхээс дүгнэвэл хуулийн энэхүү зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй хэмээн үзэж болох юм.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэг. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

Үнэлгээ:

Давж заалдах шатны шүүх иргэний хэргийг хянах хэмжээ хязгаар гэдэгт уг шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж байгаа цар хүрээг хамааруулан авч үздэг бөгөөд давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь эсхүл гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хянадаг хоёр хандлага байдаг.

Манай улсын хувьд ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүйгээр хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэж заасан нь шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хянахын зэрэгцээ гомдолд дурдсан үндэслэлээс гадна гомдол гаргаагүй нөхцөл байдлыг хянахаар ойлгогдож байна.

Гэтэл гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай энэ зохицуулалт нь мэтгэлцэх болон диспозитив зарчимтай нийцэж байгаа эсэх нь маргаантай байдаг.⁷

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд диспозитив зарчим хэрэгжинэ гэдэг нь хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа зохигчийн санаачилга буюу хүсэлтийн үндсэн

⁶ Мөн тэнд.

⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УДШ, УБ., 2007 он, 381 дэх тал.

дээр явагдана.⁸ Энэхүү зарчим нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өвөрмөц зарчмын нэг бөгөөд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол хөдөлгөгч хүч нь уг ажиллагаанд оролцож байгаа этгээдийн санаачилга байдагтай холбоотой.

Диспозитив зарчим нь шүүхэд нэхэмжлэл гаргаж, иргэний хэрэг үүсэхээс эхлээд шүүх хуралд бэлтгэх зэрэг хэрэг нэг үе шатнаас нөгөө үе шатанд шилжих, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэр гаргасны дараа зохигч давж заалдах шатанд гомдол гаргаж хэргээ хянуулах, мөн хяналтын шатаар хэргээ хянуулах тухай гомдол гаргах зэрэг иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд хамаардаг.⁹

Гэтэл хэргийг бүхэлд нь хянах энэхүү үзэл баримтлал нь дистозитив ба мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж, одоогийн зах зээлийн эдийн засгийн харилцаа, зүй тогтол, өмчлөгчдийн чөлөөт сэтгэлгээ, бүрэн эрхт байдал, үйл ажиллагаатай зарим талаар нийцэхгүй хэмээн үзэж байна. Тухайлбал, давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянаха гэдэг үзэл баримтлал нь давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа социалист нийгмийн үед төрийн эрх ашгийг хамгаалахад голлон анхаарч, хувийн шинжтэй харилцаа буюу хувийн ашиг сонирхлыг хамгаалах асуудалд бага анхаардаг байсантай холбоотой.¹⁰

Энэ нь зөвхөн онолын шинжтэй асуудал байсан бөгөөд учир нь тэр үед хувийн өмч гэж байгаагүй, тухайн үеийн нийгмийн байгуулалд зөвхөн төрийн өмч голлох үүрэгтэй байсан учир хувийн ашиг сонирхлоос төрийн ашиг сонирхол нь ямагт дээгүүр тавигдаж, давамгайл байдалтай байснаас давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлахгүйгээр төрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэргийг бүхэлд нь хянадаг байсан гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх гомдол гаргагчийн гомдолд дурдсан хүсэлтэд бага ач холбогдол өгч, гомдолд дурдаагүй зүйлийг авч хэлэлцэж, зарим талаар давж заалдах гомдол гаргагчид өөрт нь ашиггүй байдлаар анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно гэсэн утгыг бас давхар агуулдаг байна.¹¹

УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоолын 24 дүгээр заалтад "... хэргийг бүхэлд нь хянаха" гэдэг нь зохигч талын нэг нь давж заалдсан, мэтгэлцэж байгаа нөгөө тал нь хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд давж заалдах журмаар хянан шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ уг хэргийн нотлох баримт хийгээд үйл баримт, түүнд үнэлэлт дүгнэлт өгсөн байдал, шүүхийн шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүхэлд нь хянан шийдвэрлэхийг хэлнэ" гэжээ. Энэ нь давж заалдах шатны шүүх гомдол гаргагчийн гомдолдоо дурдсан хүсэлтэд бага ач холбогдол өгч, гомдолд дурдаагүй зүйлийг авч хэлэлцэж, зарим талаар анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно гэсэн утгыг агуулдаг байна. Өөрөөр хэлбэл, гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг алдагдуулж байна гэж үздэг судлаачид цөөнгүй байдаг.

Мөн хуулийн энэхүү зохицуулалтыг давж заалдах шатны шүүх гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлагдахгүй шийдвэр гаргах эрх олгосон зохицуулалт гэж үздэг.

УДШ-ийн 2009 оны 11 сарын 30-ны өдрийн 5 дугаар зөвлөмжийн 2.2-т "Шүүхийн алдааг нотлох давж заалдах шатны шүүхийн нотолгооны зүйл:

⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, МУИС-ХЗС, УБ., 2011 он, 43 дахь тал.

⁹ Мөн тэнд, 44 дэх тал.

¹⁰ Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд, УБ., 2013 он, 238 дахь тал.

¹¹ Мөн тэнд.

- Гомдлын үндэслэлд туссан үйл баримт;
- Гомдолд гарсан хариу тайлбарын үндэслэлд туссан үйл баримт;
- Гомдол болон хариу тайлбарын аль алинд нь тусгагдаагүй боловч зайлшгүй тогтоох шаардлагатай үйл баримт зэргээс бүрдэнэ гэж заасан.

Нэгэнт давж заалдах шатны шүүх хэргийг гомдол гарсан тохиолдолд хянан хэлэлцдэг тул гомдолд болон түүнд өгсөн хариу тайлбарт тусгагдсан үйл баримтад тулгуурлан анхан шатны шүүхийн шийдвэр алдаатай, эсхүл алдаагүй байгааг хянаж үзнэ. Гэхдээ давж заалдах гомдол гаргах хуульд заасан тодорхой үндэслэл байдаггүй, эсрэг сонирхолтой талууд шүүхийн шийдвэрт бодит бус үндэслэлээр ч гомдол гаргах боломжтой тул шүүх зөвхөн гомдолд дурдсан үйл баримтад л тулгуурлавал шүүхийн шийдвэрийг бүрэн дүүрэн хянаж чадахгүй юм. Тийм ч учраас ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх зөвхөн гомдолд заасан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянахаар зохицуулжээ.¹²

Мөн ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэтгэлцэх зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжих ёстой бөгөөд “тайлбарыг гагцхүү зохигч талууд гаргана (ИХШХШТХ-ийн 6.5 дахь хэсэг)” гэсэнтэй зөрчилдсөн байж болох юм.¹³

Энэ мэтчилэн дээрх зохицуулалт нь өнөөдрийг хүртэл практикт болон онолын хувьд судлаачдын дунд маргаан дагуулсаар байна.

Түүнчлэн, хуульд давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ гэж заасан учир давж заалдах шатны шүүх талуудын мэтгэлцэх эрх зөрчигдсөн гэж талуудаас гомдол гаргаагүй байхад нь шүүгч хуулийн уг заалтыг хэрэгжүүлэхийн тулд хэргийг бүхэлд нь хянаж, буцаах тохиолдол гардаг.

Иймд хуулийн энэхүү зохицуулалт нь зорилгодоо бүрэн хүрээгүй хэмээн дүгнэж болох юм.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.

ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

31.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.

Үнэлгээ:

ИХШХШТХ-д зааснаар прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход үндсэн 2 нөхцөл бүрдсэн байхыг шаардаж байна.

1. Прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах тухай төрийн байгууллагын хүсэлт байхыг;

¹² Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар, УДШ-ийн 2009 оны 11 сарын 30-ны өдрийн 5 дугаар зөвлөмж.

¹³ Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, Шүүх эрх мэдэл сэтгүүл, ШЕЗ, 2017 он, №3, 86 дахь тал

2. Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардаж байгаа юм.¹⁴

Төрийн байгууллага нь хуульд заасан эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр нэхэмжлэл гаргах болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй талаар нэхэмжлэгч талын шаардлагаар хариуцагч болсон тухайн маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэхээр прокурорт бичгээр хандсан үйл ажиллагааг төрийн байгууллагын хүсэлт гэнэ гэж тодорхойлсон байдаг.¹⁵

Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэдгийг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоолд “... прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх” үндэслэлд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор зэрэг асуудлаар Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, иргэний эрх зүйн харилцаанд оролцох явцад маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй, тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон, эрхийг түдгэлзүүлсэн, зогсоосон зэрэг/ байхыг ойлгоно...” гэж тайлбарлажээ.

Гэсэн хэдий ч энэхүү тогтоолд тухайн асуудлыг хариуцах төрийн байгууллага албан тушаалтан байхгүй бол прокурорт ямар байгууллага хүсэлт тавих нь тодорхойгүй байгаа юм.¹⁶

Түүнчлэн, ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаас харвал төрийн байгууллага хүсэлт гаргасан л бол прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохоор хуульчилсан байна. Гэтэл УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоолын 7 дахь хэсэгт “... маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй, тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй” тохиолдолд л прокурор оролцохоор заасан нь иргэний хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцох боломжийг илүү хязгаарлаж өгсөн байна.

ШИГТГЭЭ 1

Прокурор ИХШХШТХ-д заасан үндэслэлийг баримтлан Иргэний шүүх хуралд орох гэхэд шүүх УДШ-ийн 2002 оны 7 сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолын тайлбарыг үндэслэн, прокурор шүүх хуралдаанд оролцох боломжгүй гэсэн тайлбарыг өгдөг.

Прокурорын ярилцлагаас...

Монгол Улсын хууль тогтоомжид прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг Монгол Улсын Үндсэн хууль, салбар хууль хийгээд бусад эрх зүйн актуудад дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”;

2. ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно”;

¹⁴ Сум дундын 12 дугаар шүүхийн шүүгч З.Нандинцэцэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2014 он, №2 (76), 32 дахь тал.

¹⁵ Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, 2001 он.

¹⁶ Сум дундын 12 дугаар шүүхийн шүүгч З.Нандинцэцэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2014 он, №2 (76), 33 дахь тал.

3.Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно”;

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 2002 оны 7 сарын 24-ний өдрийн 236 тогтоолын 7 дахь хэсэгт “...хуулийн 31.1 дэх заалтын “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл өөрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ...төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсний “төрийн байгууллагын хүсэлт” -д Монгол Улсын Их хурал, Засгийн газар болон тэдгээрээс эрх олгосон байгууллагаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлүүлж прокурорыг оролцуулах хүсэлтийг бичгээр гаргасныг хамааруулан ойлгоно.

Прокурор төрийг төлөөлж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хуулийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Энэ заалтын “прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх” үндэслэлд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор зэрэг асуудлаар Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, иргэний эрх зүйн харилцаанд оролцох явцад маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй, тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон, эрхийг түдгэлзүүлсэн, зогсоосон зэрэг/ байхыг ойлгоно”;

5.УДШ-ийн 2010 оны 6 сарын 2-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын тухай” 2 дугаартай зөвлөмжид:

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, бусдын эрх ашгийг хамгаалж байгаа этгээд оролцох журмыг ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлд тодорхойлжээ. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд дараах хоёр үндсэн нөхцөлийг харгалзан үзнэ. Үүнд:

- Төрийн байгууллага иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах хүсэлт гаргасан байх;

- Прокурор оролцуулах тухай хүсэлт нь төрийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд үндэслэсэн байх.

Эдгээр нөхцөлд прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын нэрийн өмнөөс бус гагцхүү төрийн нэрийн өмнөөс оролцоно.¹⁷

6.Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 6 сарын 27-ны өдрийн А/62 тоот тушаалаар батлагдсан “Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан зааврын /цаашид “аргачилсан заавар” гэх/ 3.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт “Төрийн байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор шийдвэрлэсэн бол тухайн төрийн байгууллагаас итгэмжлэл авна...” гэж тус тус заасан байна.

Дээрх эрх зүйн актуудын зохицуулалтаас үзэхэд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй субъект бөгөөд ийнхүү оролцохдоо төрийг төлөөлөн, төрийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий этгээд юм.

¹⁷ Дэлгэрэнгүйг <http://www.supremecourt.mn/act/view/65> үзнэ үү.

Харин ИХШХШТХ-д заасны дагуу прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо төрийн ашиг сонирхол зөрчигдсөн үед төрийн байгууллагын хүсэлтэд үндэслэн оролцох эрхтэй байхаар хуульчилсан бөгөөд “Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн” гэдгийг хэрхэн яаж тодорхойлох нь ойлгомжгүй ба хэт ерөнхий байдлаар тусгажээ.

Үүнийг УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэг 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлдээ “...

Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэдгийг хэрхэн ойлгох шалгуур нь тодорхойгүй. Төрийн байгууллагаас хүсэлт ирэхэд прокурор үзэмжээрээ цаана нь төрийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдол байна гэдгийг хараад шүүхэд тухайн төрийн байгууллагыг төлөөлдөг. Гэтэл энэ үзэмж нь ямар нэгэн шалгуургүй тухайн прокурорын эсхүл прокурорын байгууллагын үзэмж байдаг. Нөгөө талаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн байгууллагыг төлөөлж оролцож байгаа учир төрийн байгууллагын алдаатай шийдвэрийг хамгаалах, өмгөөлөх байр сууринаас оролцдог нь прокурорын чиг үүрэгтэй зөрчилддөг” хэмээн үзсэн байна.

2017 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Прокурорын тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан УЕП-ын 2017 оны аргачилсан зааврын 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэдэгт Иргэний хуулийн 6 дугаар зүйлд заасан иргэний эрх зүйн харилцааны объект нь төрийн мэдлийнх бөгөөд төрийн эдийн болон эдийн бус баялгийг өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх зөрчигдсөнийг хамааруулна. Дараах төрлийн маргаанд прокурор төрийн байгууллагын хүсэлтээр оролцоно. Үүнд:

4.1.Төрийн хамгаалалтад байгаа байгалийн баялаг газар түүнтэй холбогдсон маргаан;

4.2.Төрийн өмчийг хувьчлахтай холбогдсон маргаан;

4.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас бусдад учирсан гэм хорыг төрөөс гаргуулахаар нэхэмжилсэн иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа;

4.4.Төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон маргаан гэж тусгайлан аргачилсан зааварт заажээ.

Дээрхээс дүгнэвэл аргачилсан зааварт тусгасан энэхүү зохицуулалтыг ИХШХШТХ-тай уялдуулан зохицуулах нь зүйтэй.

Учир нь УЕП-ын 2017 аргачилсан заавар нь зөвхөн Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах бөгөөд хууль зүйн хүчин чадлын хувьд ч ИХШХШТХ-ийн дор эрэмбэлэгдэнэ.

Иймд прокурор иргэний хэрэгт төрийг төлөөлөн оролцох боломжийг ИХШХШТХ-аар нарийвчлан зохицуулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

Түүнчлэн, хуулийн үзэл баримтлал болон шүүх хуралдаанд прокурор оролцох тухай УЕП-ын аргачилсан заавраар прокурор нь төрийн байгууллагыг төлөөлөн оролцохоор заасан байдаг бөгөөд гэтэл УДШ-ийн зөвлөмжид зааснаар прокурор нь тухайн байгууллагын нэрийн өмнөөс бус төрийн нэрийн өмнөөс оролцоно гэсэн нь өөр хоорондоо зөрчилтэй байна. Эдгээр зөрчилтэй зохицуулалтууд нь шүүх хуралдаанд оролцох үед хүндрэл үүсгэдэг.¹⁸

¹⁸ 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэгийн хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлээс.

Мөн ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтыг практикт хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал бий болгож буй өөр нэг асуудал нь төрийн өмчит компани төрийн байгууллагад хамаарах эсэх асуудал юм.

ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарт 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг заасан заалтыг тайлбарлахдаа:

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход үндсэн хоёр нөхцөл бүрдсэн байна. Үүнд:

1. Прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах тухай төрийн байгууллагын хүсэлт байна. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд төрийн байгууллагад хамаарахгүй болохыг анхаарах нь зүйтэй.

2. Төрийн ашиг сонирхол зөрчигдсэн байна. Прокурор төрийн байгууллагын хүсэлтийг хүлээн авч, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл энэ хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эсэхийг шийдвэрлэнэ. Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн боловч прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай санал гаргаагүй бол шүүх санаачилгаараа прокурорыг оролцуулах эрх хуульд тусгагдаагүй байна¹⁹ хэмээн тайлбарлажээ.

УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэг 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлдээ “...Төрийн хоёр байгууллагын хоорондох маргаан гарвал прокурор хэрхэн оролцох, төрийн өмчит компанийн хүсэлтийг төрийн байгууллагын хүсэлт гэж үзэх үү? гэдэг нь тодорхой биш байна” гэж хэлснээс үзэхэд төрийн өмчит компанийн гаргасан хүсэлтийг төрийн байгууллагын хүсэлт гэж үзэх эсэх нь прокуроруудын хувьд ойлгомжгүй, эргэлзээ бүхий асуудал хэвээр байгааг харж болох юм.

Нэг талаас, прокурор нь иргэний эрх зүйн харилцаа бус эрүүгийн эрх зүйн харилцааны гол субъект болохын хувьд ЭХХШТХ-д зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцдог.

Түүнчлэн, өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын судалгааны явцад прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо практикт ажилладаг өмгөөлөгчдөөс ялгамжтай байдлаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг. Нэг талаас прокуроруудын иргэний эрх зүйн мэдлэг дутмаг байдал, нөгөө талаас эрүү болон иргэний хэргийн шүүх хуралдааны процесс өөр хоорондоо ялгаатай байдлаар явагддагтай холбоотой хэмээн тайлбарлаж байна.

Дээрхээс дүгнэхэд прокуроруудын иргэний эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь дээр дурдсан төрийн өмчит байгууллага төрийн байгууллагад хамаарах эсэх асуудал дээрээс тодхон харагдаж байна. Учир УДШ-ээс гаргасан ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар 2007 онд хэвлэгдэн гарсан байх бөгөөд энэхүү тайлбарт төрийн өмчит компани төрийн байгууллагад хамаарахгүй болохыг тодорхой байдлаар тайлбарлан өгчээ. Гэтэл прокурорууд төрийн өмчит байгууллага төрийн байгууллагад хамаарах эсэх нь тодорхойгүй байна хэмээн тайлбарлаж байгаа нь иргэний эрх зүйн мэдлэг дутмаг болохыг харуулахын зэрэгцээ прокурор үйл ажиллагааны чиглэл бараг бүхэлдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход чиглэсэн байдагтай холбоотой юм.

Мэргэшсэн салбар, чиглэл өөр учир прокурорууд өөрийн эзэмшсэн мэргэжилдээ чадварлаг байж болох ч мэргэшээгүй чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа алдаа дутагдал гаргахыг үгүйсгэх аргагүй юм. Учир нь арван хуруу тэгш

¹⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УДШ, 2007 он, 107 дахь тал.

хүн гэж байдаггүйтэй адил ажил мэргэжлийн хувьд өмгөөлөгч, шүүгч, прокурорууд бүгд адилхан хуульч гэх статустай ч чиг үүрэг, салбар эрх зүйгээрээ өөр хоорондоо ялгагдах онцлог шинжтэй гэдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилалд төрийн өмчит үйлдвэрийн газар хамаарахаар хуульчилсан байдаг нь энэхүү эргэлзээг бий болгоход хүргэсэн гэж үзэж болох юм.

Мөн практикт прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлгүйгээр оролцдог байсныг эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, шүүгчид иргэний эрх зүйн эрх тэгш байх зарчмыг алдагдуулж байна хэмээн үзэх тохиолдол цөөнгүй байсан.

Учир нь иргэний эрх зүйн харилцаа нь талууд тэгш эрхийг хангахад илүүтэй чиглэдгээрээ бусад салбар эрх зүйгээс ялгагддаг.

ШИГТГЭЭ 2

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуулийн этгээдийн өмчийн хэлбэр эрх хэмжээгээр ялгаварлахгүйгээр эрх тэгш байх зарчимд үндэслэн явагддаг. Энэ бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудын нэг. Гэтэл төр иргэний эрх зүйн харилцааны субъект болж иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагийн хувьд ажиллагаанд оролцогчтой тэгш эрхтэй байх ёстой. Маргаан үүсгэж байгаа төрийн байгууллагын хүсэлтээр прокурор ямар нэгэн итгэмжлэлгүйгээр төрийн байгууллагыг төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь шүүхийн өмнө тэгш байх зарчим алдагдахад хүрч байгаа төдийгүй ИХШХШТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.5.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2, 36.4 дэх заалтуудтай зөрчилдөж байна.

Шүүгчийн ярилцлагаас...

2002 оны Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "...Прокурор иргэний хэрэгт итгэмжлэлгүйгээр оролцоно" гэж заасан байсан бөгөөд УЕП-ын 2015 аргачилсан зааврын 3 дугаар бүлгийн 3.1.1 дэх хэсэгт "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцох ба энэ тохиолдолд итгэмжлэл шаардахгүй" гэж тус тус заасан байсныг шинэчлэн найруулсан Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцох"-оор хуульчилж, УЕП-ын 2017 оны аргачилсан зааврын 3.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт "Төрийн байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор шийдвэрлэсэн бол тухайн төрийн байгууллагаас итгэмжлэл авна..." гэж заажээ.

Өөрөөр хэлбэл, прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо төлөөлж буй байгууллагаасаа итгэмжлэл авахаар заасан нь иргэний эрх зүйн эрх тэгш байх зарчимтай уялдуулан өөрчлөн найруулсан зохицуулалт болсон хэмээн үзэх үндэслэлтэй байна. Гэсэн хэдий ч практикт прокурор тухайн төлөөлж буй төрийн байгууллагаасаа итгэмжлэл авалгүй шүүх хуралдаанд орох тохиолдол гарч байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, төрийн байгууллагууд хөдөлмөрийн маргаан бүхий иргэний хэрэгт прокурорыг оролцуулах хүсэлт ихээр ирүүлдэг. Энэ тохиолдолд хэрхэн оролцох нь хуульд тусгагдаагүй. Бид зөвхөн байгууллагын дотоод заавраар

дээрх тохиолдлуудад орохгүй гэсэн чиглэл бариад ажиллаж байна²⁰ хэмээн УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэг 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлдээ дурдсан байх бөгөөд үүнийг Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан УЕП-ын 2017 оны аргачилсан зааврын 3.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Төрийн хоёр байгууллагын хоорондох болон хөдөлмөрийн маргаантай иргэний хэрэгт прокурор оролцуулах хүсэлт ирүүлсэн, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж прокурор үзээгүй бол дээд шатны прокурорт танилцуулж, түүний зөвшөөрснөөр албан тоотоор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцохгүй тухай хариу өгнө” гэж нарийвчилсан байдлаар зохицуулсан байна.

Гэтэл прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар нь зөвхөн прокурорын байгууллагын хүрээнд үйлчлэх бөгөөд энэхүү зохицуулалтыг шүүгч, өмгөөлөгч, бусад этгээд мэдэх боломж хязгаарлагдмал юм. Иймд эргэлзээтэй байдал бий болгохгүйн тулд хуулиар тусгайлан зааж, эсхүл УДШ-ээс тайлбар, зөвлөмж гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

Сум дундын 12 дугаар шүүхийн шүүгч З.Нандинцэцэг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцоо” сэдэвт нийтлэлдээ “...Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх 2011 онд 475 хэрэг хянан шийдвэрлэснээс төрийн байгууллага нэхэмжлэгчээр оролцсон 15 хэрэг, хариуцагчаар оролцсон 7 хэрэг, 2012 онд 447 хэрэг хянан шийдвэрлэснээс 18 хэрэгт төрийн байгууллага нэхэмжлэгчээр оролцож, 7 хэрэгт хариуцагчаар, 2013 онд 739 иргэний хэрэг шийдвэрлэснээс 55 хэрэгт төрийн байгууллага нэхэмжлэгчээр, 17 хэрэгт хариуцагчаар тус тус оролцсон байна. Дээрх судалгаанаас үзэхэд төрийн байгууллага нэхэмжлэгч, хариуцагчаар оролцсон маргаан бүхий хэрэгт тухайн байгууллагын хүсэлтээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй байгаа нь цаашид маргаан бүхий хэргийн тухайд төрийн байгууллагын хүсэлтээр прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Харин онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх зарим хэргүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүсэлт гаргагч оролцдог бөгөөд дээрх ажиллагаанд төрийн ашиг сонирхол хөндөгдөх боломжтой учир онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх зарим хэргүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төрийг төлөөлж оролцож байх нь илүү зохистой”²¹ хэмээн үзжээ.

Харин УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэг “...прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн байгууллагатай нэг тал болж төрийн байгууллагын буруутай үйл ажиллагаа байсан ч шууд тэдний талд санал, тайлбар хэлж, тухайн байгууллагын өмгөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг байсан. Гэтэл төрийн байгууллага хэргийн оролцогч болж шүүх дээр хянан шийдвэрлэгдсэн иргэний маргаантай хэргүүдэд /ихэвчлэн хариуцагч болдог/ төрийн байгууллагын ялагддаг шалтгаан нь жишээлбэл, өмч хувьчлахдаа гэрээгээ хууль зүйн үндэслэл журмын дагуу хийгээгүй, төрийн байгууллагын удирдлагуудын хууль, эрх зүйн мэдлэг дутуугаас хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох нь тодорхой хэргүүдэд прокурор илтэд зөв мэтээр дүгнэж ярих нь прокурорын шударга үнэний зарчимтай зөрчилддөг

²⁰ 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэгийн хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлээс.

²¹ Сум дундын 12 дугаар шүүхийн шүүгч З.Нандинцэцэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2014 он, №2 (76), 34 дэх тал.

төдийгүй шүүхийн шийдвэр төрийн талд гарахгүй байх шалтгаан болдог”²² гэж үзсэн байна.

Нөгөөтээгүүр, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрх тэгш байх зарчимд үндэслэдэг гэтэл ийнхүү прокурорыг оролцуулах нь энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд төдийлөн ач холбогдолтой зохицуулалт биш юм. Учир нь иргэний эрх зүйн салбар хуулиуд болон процесс ажиллагаа нь эрүүгийн эрх зүйгээс ялгаатай болохын хувьд прокурор тэр бүр иргэний эрх зүйн харилцаанд оролцох дадал туршлага байдаггүй мөн прокурорын үндсэн чиг үүрэг нь улсын яллагч буюу яллах чиг үүрэг бүхий субъект атал иргэний хэрэгт төрийн байгууллагыг өмгөөлөх үйл ажиллагаа явуулахаар прокурорын чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

Дээрх хоёр тайлбараас энэхүү асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг эрэлхийлж үзвэл прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдлыг ИХШХШТХ-д нарийвчлан зохицуулж өгснөөр энэхүү асуудал шийдвэрлэгдэх боломжтой. Гэхдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорыг огт оролцуулахгүй байх нь өрөөсгөл бөгөөд зайлшгүй тохиолдолд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь зүйтэй гэж үзэж байна.

Тухайлбал, Прокурор хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хэмээн үзэж цагдан хорих санал гаргах, яллах дүгнэлт үйлдэж шүүх рүү шилжүүлж, шүүх хуралдаанд төрийн төлөөлж ялын санал хэлдэг. Гэтэл прокурорын гэм буруутай гэж үзэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар санал гаргасан, яллах дүгнэлт үйлдэж шүүх рүү шилжүүлсэн хүнийг шүүхээс гэм буруугүй гэж тогтоосон /цагаатгах тогтоол гарсан/, ял эдэлж байгаад цагаатгагдан суллагдсан, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад эрх нь зөрчигдсөн хүн иргэний хэргийн шүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь зүйтэй.

Учир нь нэхэмжлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн хууль бус ажиллагаа явуулсан нь эрүүгийн хэргийн шүүхээр тогтоогдож улмаар нэхэмжлэгч өөрт учирсан хохирлоо арилгуулахаар иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байх тул хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг хийгээд яллах дүгнэлт бусад эрх зүйн хэлбэр үйлдэх болсон шалтгаан нөхцөл, хууль зүйн үндэслэлийг тайлбарлах, хамгаалах, тухайн үеийн нөхцөлд байдалд хууль зүйн дүгнэлт өгөх хамгийн боломжит субъект нь прокурор юм. Нөгөөтээгүүр, прокурор иргэний хэрэгт төрийг төлөөлөн оролцож байгаа нь төрийг өмгөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй мэт боловч өөрийн үйлдлийн эрх зүйн үндэслэлийг тайлбарлаж байна хэмээн үзэх үндэслэлтэй учир дээрх тохиолдолд хуульд заасан яллах чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас бусдад хохирол учрах болсон шалтгаан нөхцөлийг тайлбарлаж, өөрийн хийсэн үйлдлийг хууль зүйн үндэслэл журмын дагуу хамгаалах, тайлбарлах боломжийг бүрдүүлэх юм.

Нөгөөтээгүүр, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хариуцагчаар прокуророос өөр субъектийг иргэний хэрэг оролцуулбал тухайн этгээд прокурорын тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай байж болох юм гэсэн дотоод итгэл үнэмшил хийгээд хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийн

²² 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт УЕПГ-ын хяналтын прокурор, Х.Батчимэгийн хэлэлцүүлсэн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход гарч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт илтгэлээс.

талаар төдийлөн сайн мэдэх боломжгүй юм. Иймд дээрх тохиолдол болон бусад шаардлагатай цөөн хэдэн тохиолдолд прокурорыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй бөгөөд хуульд заасан төрийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд төрийн байгууллагын хүсэлтээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдлыг хязгаарлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэг. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

Үнэлгээ:

Иргэний хэргийн оролцогчид Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "... шүүхийн шийдвэрт давж заалдах... эрхтэй" гэж мөн ИХШХШТХ-аар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэрт хуульд заасан үндэслэл журмын дагуу гомдол гаргаж, давж заалдах эрхтэй болохыг хуульчилсан байдаг.

ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан үзнэ" гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид төдийгүй мэргэжлийн өмгөөлөгчдийн дунд хэрхэн ойлгохтой холбоотой хүндрэлтэй байдал ажиглагддаг. Давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, давж заалдах болон хяналтын гомдлын зааг ялгааны талаар сайн мэддэггүйгээс гомдол гаргахгүйгээр нөгөө талын гомдол гаргаснаар өөрийнх нь асуудал давхар хянагдах мэт өрөөсгөл ойлгосноор давж заалдах гомдол гаргах эрхээ эдэлж чадахгүй, дараагийн шатны шүүхэд гомдол гаргах боломжгүй болж хохирох байдал ажиглагдаж байна.²³

ИХШХШТХ-ийн 166.4.-т заасан "хэргийг бүхэлд нь хянаха" гэсэн шаардлагыг гомдол гаргагчийн эрх ашигт урвуугаар хэрэглэх нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн диспозитив зарчимд ямар байдлаар хамаарах вэ? гэдэг асуудал гарна. Жишээлбэл, Нэхэмжлэгч "О" нь хариуцагч байгууллагаас ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор нэхэмжилсэн ба хариуцагч нэхэмжлэлийн шаардлагаас зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн хэмжээгээр анхан шатны шүүх шийдвэрээ гаргажээ. Нэхэмжлэгч шаардлагаа бүрэн хангуулахаар давж заалдах гомдол гаргасан. Гэтэл давж заалдах шатны шүүх түүний гомдлоор хэргийг хянахдаа "...Хөдөлмөрийн тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн" гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.²⁴

Хяналтын шатны шүүх Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.2 дахь хэсэг, ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасантай давж заалдах шатны шүүхийн магадлал нийцээгүй гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, талууд хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн эсэх асуудлаар маргаагүй байхад талуудын маргаагүй асуудлаар дүгнэлт хийсэн нь буруу байна. Аливаа хэрэг маргааны агуулгыг бүрдүүлсэн бодит факт, нөхцөл байдал, харилцааг танин мэдсэний эцэст тэдгээрийг зөв тодорхойлж, эрх зүйн үүднээс болон хэрэглэх гэж буй хуулийн байр сууринаас тайлбарласан үр

²³ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхч Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

²⁴ Мөн тэнд.

дүнг шүүхийн дүгнэлт /шийдвэр/ гэж үзнэ. Энэ утгаараа шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлага нь өөрөө шүүхийн шийдвэр талуудын бодит үнэнд нийцсэн тайлбар, хуульд заасан журмын дагуу гаргаж өгсөн нотлох баримтад үндэслэсэн мэтгэлцэх зарчмыг өөртөө агуулж байна гэж тайлбарлаж болох юм.²⁵

Хэрвээ шүүх ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд заасан мэтгэлцэх зарчмыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, хэргийн оролцогчийн тайлбар, нотлох баримтаа гаргаж өгөх эрхийг хязгаарласан нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх нь ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээний /бүрэн эрх/ хүрээнд шийдвэрийг хүчингүй болгодог. Хуулийн 166.4 дэх хэсгийн текстээс үзэхэд шүүхийн шийдвэрийг “бүхэлд нь хянана” гэдгийг шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хянахын зэрэгцээ гомдолд дурдсан үндэслэлээс гадна гомдол гаргаагүй хэргийн оролцогчийн хувьд хэргийг хянахаар ойлгогдож байна. Энэ тохиолдолд давж заалдах шатны шүүх өөрийн санаачилгаар хэргийн үйл баримтыг олж тогтоох официал зарчмыг хэрэгжүүлэх үүрэгтэй гэж ойлгох уу. Гэтэл хэргийг “бүхэлд нь” хянах энэ үзэл баримтлал нь диспозитив ба мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж, эдийн засгийн харилцаа, зүй тогтол, өмчлөгчдийн чөлөөт сэтгэлгээ, бүрэн эрхт байдал, үйл ажиллагаатай зарим талаар нийцэхгүй байна хэмээн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг “Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар” сэдэвт бүтээлдээ дурджээ.

Ийнхүү хэргийн оролцогчид давж заалдах эрхээ хэрэгжүүлэхийн тулд ИХШХШТХ-ийн давж заалдах шатаар хэрэг хянах ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг судлах, хуульчид, шүүгчид дээрх хэм хэмжээг зөв тайлбарлан практикт хэрэглэх чадварыг эзэмшсэн байх нь чухал.²⁶

Гэтэл практикт хуулийн дээрх заалтыг учир дутагдалтай эсэх дээр өнөөдрийг хүртэл ихээхэн маргадаг. Өөрөөр хэлбэл, хуулийн энэхүү зохицуулалтыг зөв, буруу гэх үзэл өнөөдрийн хүртэл маргаан дагуулсаар байна.

Тухайлбал, давж заалдах шатны шүүх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянах гэдгийг процессын хуулийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчсөн, нийтийн буюу төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлага гарч байгаа тохиолдлыг ойлгоно.

Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх хувийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа хэргийн хувьд давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хэргийг хянах ба энэ нь Иргэний процессын эрх зүйн диспозитив зарчмын агуулгатай тохирдог. Давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянана гэдэг нь талуудын хувийн бүрэн эрхт байдалтай холбоотой ба давж заалдах шатны шүүх гомдлын хүрээнээс хэтэрч, өөрийн санаачилгаар маргалдаж байгаа талуудын шүүхэд хандаж хянуулахаар хүсэлт тавиагүй асуудлыг хөндөж, үүнийгээ үндэслэл болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгож байгаа нь мэтгэлцэх зарчимд харшилж байна гэж үзэх үндэслэлтэй²⁷ гэж судлаач Д.Хуяг үзсэн байна.

Харин ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарт “...Давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлууд бүрэн тогтоогдсон эсэх, анхан шатны шүүхийг нотлогдсон гэж үзсэн нөхцөл байдал нь тогтоогдож байгаа эсэх, шүүхийн шийдвэрт дурдсан дүгнэлт нь нотлох баримтад тулгуурлаж байгаа эсэх, тухайн маргаантай харилцааг зохицуулсан

²⁵ Мөн тэнд.

²⁶ Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд, УБ., 2013 он, 227 дахь тал.

²⁷ Мөн тэнд, 241 дэх тал.

хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх, хэргийг хуульд заасан бүрэлдэхүүнээр хянан хэлэлцсэн эсэхийг хянан. Иймд зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянах нь зүйтэй гэж үздэг.²⁸

Ийнхүү эсрэг тэсрэг байр суурийг илэрхийлж буй энэхүү асуудлын цаана иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах ёстой юу? давж заалдах гомдлын хүрээнд хянах нь зөв үү? гэсэн асуултад хамгийн тохиромжтой хариултыг олох явдал юм.

Энэхүү асуултын хариултыг олохын тулд бусад орны хууль тогтоомжийг өөрийн орны онцлогт нийцүүлэн судлан үзэх нь зүйтэй ч үүнээс өмнө бусад салбар эрх зүйд энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар судлан үзэх нь зүйтэй болов уу?. Манай улсын ЗХШХШТХ-ийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт “Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянах ба хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй” хэмээн заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, ЗХШХШТХ-д захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдлын хүрээнд хянахаар хуульчилсан байх бөгөөд шаардлагатай тохиолдолд буюу хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэхээр хуульд тусгайлан зааж өгсөн байна.

Дээрхээс дүгнэвэл, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх ч мөн адил хэргийг гомдлын хүрээнд хянан үзэх нь зүйтэй, гагцхүү хуульд хэргийг бүхэлд нь хянан үзэх шаардлагатай тохиолдлыг ЗХШХШТХ-д хуульчилсантай адилаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаадын зарим орны уг зохицуулалтын талаарх харьцуулалт²⁹

ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 525 дугаар зүйлд “Айлтган заалдах шатны шүүх хэргийг талуудын хүсэлт гаргасан хүрээнд хянаж үзнэ”, 536 дугаар зүйлд “Анхан шатны шүүхийн шийдвэрт зөвхөн гомдолд дурдсан үндэслэлийн хүрээнд өөрчлөлт оруулна” гэж заасан. Эндээс үзэхэд хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагаа нь давж заалдах шатны шүүх хэргийг зөвхөн давж заалдах гомдол гаргасан этгээд ба түүнд гаргасан тайлбарын хүрээнд хэргийг хянах асуудлыг анхаарна гэсэн утгыг агуулдаг байна.³⁰

ОХУ-ын 2002 оны 11 дүгээр сарын 14-нд батлагдсан Иргэний процессын хуулийн 327 дугаар зүйлд /Давж заалдах шатны шүүх хэргийг хянах хүрээ/³¹;

1. Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдолд болон татгалзалд дурдсан үндэслэлийн хүрээнд хэргийг хянан хэлэлцэнэ. Давж заалдах шатны шүүх хэрэгт байгаа болон нэмэлт нотлох баримтыг үнэлнэ. Хэрэв нэмэлт нотлох баримтыг анхан шатны шүүхэд хэргийн оролцогч этгээдээс үл шалтгаалан гаргаж өгөх боломжгүй болсон нь үндэслэлтэй, мөн шүүх үүнийг хүндэтгэн үзэх шалтгаантай хэмээн үзсэн тохиолдолд Давж заалдах шатны шүүх хүлээн авна. Шинэ нотлох баримтыг хүлээн авсан тухай давж заалдах шатны шүүх магадлал гаргана.

2. Давж заалдах ажиллагааны журмаар шүүхийн шийдвэрийн зөвхөн зарим хэсэгт гомдол гаргасан бол зөвхөн гомдолтой хэсгийг давж заалдах шатны шүүх

²⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УДШ, УБ., 2007 он, 369 дэх тал.

²⁹ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /Гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

³⁰ Д.Хуяг, Давж заалдах шатны шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ хязгаар, Монголын төр эрх зүй сэтгүүл, УБ., 2005 он, №2, 5 дахь тал.

³¹ Гражданский процессуальный кодекс Российской Федерации от 14.11.2002 N138-ФЗ

анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль ёсны эсэх болон үндэслэлтэй эсэхийг шалгана. Давж заалдах шатны шүүх хууль ёсны байх шаардлагын үүднээс анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянах эрхтэй.

3. Давж заалдах гомдлын үндэслэлээс үл хамаарч давж заалдах шатны шүүх анхан шатны шүүх энэхүү Кодексын дөрөвдүгээр хэсгийн 330 дугаар зүйлд заасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох процессын эрхийн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг шалгана.

Энэ нь давж заалдах шатны шүүх давж заалдах гомдолд дурдагдаагүй боловч хэргийн болон шүүхийн харьяалал зөв эсэх, төлөөлөгчийн итгэмжлэл хуулийн шаардлага хангасан эсэх, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг төлөөгүй буюу дутуу төлсөн эсэх, хуваагдахгүй эд хөрөнгөтэй холбогдсон маргааны хамтран хариуцагчдад хариуцлага хүлээлгэх тухай, хэргийг шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн хуулийн заалтад нийцэж байгаа эсэх зэрэг процессын хуулийн заалтуудыг зөв хэрэглэсэн эсэхийг хянах тухай асуудлыг хамаарч байна.³²

Япон Улсын Иргэний процессын хуулийн 296 дугаар зүйлийн 296.1 дэх хэсэгт “Шүүхийн хэлэлцүүлэг нь талууд анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөхийг шаардаж байгаа хүрээнд явагдана” гэж хуульчилсан байдаг. Япон Улсын Иргэний процессын хуулийн 304 дугаар зүйлийн 304.1 дэх хэсэгт “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох болон өөрчлөхдөө гомдлын хүрээнд явуулна” гэж заажээ. Энэ нь давж заалдах гомдол гаргахад гомдлынхоо хүрээг тодорхойлохыг шаарддаггүй шүүх хуралдаан дуусах хүртэл гомдол гаргагч нь гомдлын хүрээгээ ихэсгэж болдог, гомдол гаргаагүй эсрэг тал нь мөн давж заалдах гомдол гаргах боломжтой байдагтай холбоотой байдаг. Иймээс давж заалдах шатны шүүх нь давж заалдах гомдлоор хязгаарлагдалгүй анхан шатны шүүхийн адилаар нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг байна.³³

Манай улсын хувьд давж заалдах шатны шүүх гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянахаар зохицуулсан зохицуулалт судлаачдын дунд ихээхэн маргаан дагуулдаг.

ХБНГУ-ын хуульч Юпп Ёоахимски манай улсын хуулийн зохицуулалтыг судлан үзээд “... Давж заалдах шатны шүүх хэргийг илүү өргөн хүрээнд хянадаг. Давж заалдах гомдлын үндэслэлд заасан зүйлсийг шүүх харгалзан үзэх хэрэгтэй ч зөвхөн түүнд хязгаарлагдалгүй хэргийг бүхэлд нь хянана. Гэхдээ энэ нь эрх зүйн хэм хэмжээг үр дүнтэй хэрэглэхэд саад учруулж байна. Учир нь энэ зохицуулалт мэтгэлцэх зарчмыг зөрчөөд зогсохгүй давж заалдах шатны шүүхэд ихээхэн ачаалал нэмж байна”³⁴ хэмээн үзжээ.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” сэдэвт хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн сайд асан С.Бямбацогт “... 2015 онд нийтдээ шүүх дэх иргэний хэрэг маргаан 35 орчим хувь байсан бол 2016 онд даруй 45 хувь болж, жилдээ 10 хувиар нэмэгдэж байна. Үүний цаана иргэдийн өмч хөрөнгө, эдийн болон эдийн бус баялаг ард иргэдийн амьдралтай холбоотой асуудал яригдаж байна. Тийм учраас хуулиа боловсронгуй болгох, зөв хэрэглэх, хэрэгжүүлэх хуулийн дагуу шийдвэрээ зөв гаргах бол нэлээд чухал асуудал юм. Иймд өнөөдөр бид хуулийг хэрэгжүүлэх, хууль иргэн бүрт тэгш, хүртээмжтэй, ялгаваргүй ижил тэгш үйлчилдэг байх зарчмыг барьж ажиллах

³² Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

³³ Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, Шүүх эрх мэдэл сэтгүүл, ШЕЗ, 2017 он, №3, 84-85 дахь тал.

³⁴ Юпп Ёоахимски, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Мюнхен хот, 2004 он, 402 дахь тал.

хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хэн нэгэнд хууль өөр өөр үйлчилдэг байж таарахгүй” гэж хэлсэн байна.³⁵


Сүүлийн жилүүдэд иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн ачаалал нэмэгдэж байгаа. Үүнийг Монгол Улсын шүүхийн тайлангаас судлан үзвэл:

Хүснэгт 3. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн байдал³⁶

№	Маргааны төрөл	Онууд		Өсөлт, бууралт	
		2016 он	2017 он	Тоо	Хувь
1	Нийт (хүлээн авсан)	3475	4167	692	19.9
2	Нийт шийдвэрлэсэн	3143	3776	633	20.1
3	Үүнээс	Хянан шийдвэрлэсэн бүгд		3108	3721
4		Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн		13	38
5		Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан		22	17
6	Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан		54	70	16
7	Давж заалдах гомдлоосоо татгалзсан		44	39	-5
8	Үлдэгдэл		234	282	48

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2018 оны 3 дугаар улиралд нийт 2766 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс 1190 хэрэг буюу 43 хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 867 хэрэг буюу 31.3 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 709 хэрэг буюу 25.6 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.³⁷

График 1. Шийдвэрлэсэн хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал³⁸



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2018 оны 3 дугаар улиралд 2766 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар буурсан байна.

Иргэний хэргийн шүүхийн 2018 оны жилийн эцсийн тайлан мэдээ гараагүй байгаа учир 2017 оны иргэний хэргийн шүүхийн тайлангаас жилд шийдвэрлэдэг хэргийн тоог харуулахыг зорилго.

Иргэний хэргийн анхан шатны шүүх 2017 онд нийт 63220 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11331 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж буцаах, харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, 45223 хэргийг хянан шийдвэрлэж, 6656 хэргийн үлдэгдэлтэй байжээ. Энэ үед анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 940 хэрэг буюу 2 хувиар буурсан байна.³⁹

³⁵ 2016 оны 12 сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл” хэлэлцүүлгийн тэмдэглэлээс.

³⁶ Монгол Улсын Шүүхийн тайлан /2017 он/, ШЕЗ,УБ., 2018 он, 236 дахь тал.

³⁷ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн албан ёсны цахим хуудас, Монгол Улсын Шүүхийн 2018 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлангаас, Дэлгэрэнгүйг <http://www.judoinstitute.mn/main/233--2018-3-.html> үзнэ үү.

³⁸ Мөн тэнд.

³⁹ Монгол Улсын Шүүхийн тайлан /2017 он/, ШЕЗ,УБ., 2018 он, 229 дэх тал.

Харин иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд улсын хэмжээнд 2017 онд нийт 4167 хэрэг хүлээн авч, 3721 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байна. энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 613 буюу 19.7 хувиар өссөн байна.⁴⁰

Нийслэлийн давж заалдах шатны шүүх 2017 онд шийдвэрлэсэн нийт хэргийн магадлалыг судлан үзэхэд, ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан заалтыг хэрэглэж дүгнэсэн нь харьцангуй цөөн байна. Ихэвчлэн хууль хэрэглээний болон тооцоолол, найруулгын алдаа гаргасныг давж заалдах шатны шүүхээс 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасныг үндэслэн өөрчлөх замаар залруулах боломжтой гэж дүгнэсэн байна.⁴¹

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар сэдэвт бүтээлдээ ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан заалтыг давж заалдах шатны шүүхээс хэрхэн хэрэглэсэн талаар хяналтын шатны шүүх дүгнэлт хийсэн байдлыг УДШ-ийн 2015 - 2017 оны тогтоолуудыг судлан 4 төрөл болгон авч үзсэн байна. Үүнд:

1. Анхан шатны шүүх ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт заасныг зөрчиж, алдаатай дүгнэлт хийснээс шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байхад давж заалдах шатны шүүх хэвээр үлдээснээр мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж дүгнээд өөрөөр дүгнэлт хийж шийдвэр магадлал хүчингүй болгож нэхэмжлэл хэрэгсэхгүй болгосон. /УДШ-ийн 2015 оны 759 дугаар тогтоол Б.Б –ийн нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдох маргаан/;

2. Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянахдаа анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэх байтал маргааны үйл баримт бүрэн тогтоогдоогүй, эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй гэж шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон нь ИХШХШТХ-ийн 168 дугаар зүйлийн 168.1.1-т нийцээгүй, 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлээгүй гэж магадлалыг хүчингүй болгож шийдвэрт нь дүгнэлт хийж өөрчлөлт оруулсан. /УДШ-ийн 2015 оны 548 дугаар тогтоол/;

3. УДШ-ийн тогтоолоор шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож буцаахдаа ихэвчлэн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн алдааг илрүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж дүгнэсэн байна. /УДШ-ийн 2017 оны 1135 дугаар тогтоол/;

4. УДШ магадлалыг хэвээр үлдээхдээ анхан шатны шүүх Иргэний хуулийн холбогдох заалтыг зөв баримтлаагүй, мөн тооцооны алдаа гаргасныг давж заалдах шатны шүүхээс залруулж, шийдвэрт өөрчлөлт оруулсан нь ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт нийцсэн гэж дүгнэсэн байна. /УДШ-ийн 2015 оны 1117 дугаар тогтоол/⁴²

Ийнхүү судлан үзсэний үндсэн дээр тэрээр давж заалдах шатны шүүх хувийн эрх зүйн /материаллаг эрх зүйн/ маргааны хувьд зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хэргийг хянах нь иргэний процессын эрх зүйн диспозитив зарчмын агуулгатай тохирч байна. Харин хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс процессын хуулийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчсөн, нийтийн буюу төр нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлага гарч байгаа тохиолдолд буюу официал

⁴⁰ Мөн тэнд, 236 дахь тал.

⁴¹ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

⁴² Мөн тэнд.

зарчмын үүднээс хэргийг бүхэлд нь хянах зарчим үйлчлэх ялгааг хуулийн уг зохицуулалтанд нэмэлтээр тодруулж оруулах шаардлагатай⁴³ гэж үзсэн байна.

Дээрхээс дүгнэвэл, иргэний эрх зүйн харилцаа нь талуудын эрх тэгш байх зарчимд үндэслэдэг. Гэтэл хуульд гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянахаар заасан нь талуудын дээрх эрхийг зөрчиж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Иймээс энэхүү зохицуулалтыг өөрчлөн найруулж, мэтгэлцэх болон диспотив зарчимд нийцүүлэн хуульчлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Манай улсын ИХШХШТХ-ийг 2002 эхлэн дагаж мөрдсөнөөс хойш өнөөдрийг хүртэл арван зургаан жилийн хугацааг ардаа үджээ. Энэ хугацаанд ИХШХШТХ нь харьцангуй тогтвортой үйлчилж ирсэн боловч цаг хугацааны явцад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа дутагдалтай, тодорхой бус практикт хэрэгжихэд хүндрэлтэй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудтайгаа зөрчилдсөн заалтуудыг судлан үзэх зайлшгүй шаардлага бий болсон байна. Иймд энэхүү үнэлгээгээр ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт заасан заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасан прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцох тухай зохицуулалт нь практикт хэрэгжихэд хүндрэлтэй, судлаачдын дунд олон талын маргаан дагуулсан заалтуудын нэг юм. Тухайлбал, прокурорын үндсэн чиг үүрэг нь улсын яллагч буюу яллах чиг үүрэг бүхий субъект атал иргэний хэрэгт төрийн байгууллагыг өмгөөлөхөөр зохицуулсан прокурорын үндсэн чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

Иймд төрийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд төрийн байгууллагын хүсэлтээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдлыг хязгаарлах нь зүйтэй. Гэхдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорыг огт оролцуулахгүй байх нь учир дутагдалтай Учир нь прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй тохиолдолд оролцох нь зүйтэй. Тухайлбал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь зүйтэй гэж үзэж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "... шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" гэж заасан нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, иргэн хуулийн этгээдэд хамааралтай бөгөөд энэхүү заалт нь тэдгээрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бодит баталгаа юм. Энэхүү эрхийнхээ дагуу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь өөрийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт "Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ" гэж заасан нь шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хянахын зэрэгцээ гомдолд дурдсан үндэслэлээс гадна гомдол гаргаагүй хэргийн оролцогчийн хувьд хэргийг хянахаар ойлгогдож байна.

⁴³ Мөн тэнд.

Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх гомдол гаргагчийн гомдолд дурдсан хүсэлтэд ач холбогдол бага өгч, гомдолд дурдаагүй зүйлийг авч хэлэлцэж, зарим талаар давж заалдах гомдол гаргагчид өөрт нь ашиггүй байдлаар анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно гэсэн утгыг давхар агуулдаг. Тиймээс ч энэхүү заалт нь мэтгэлцэх болон диспозитив зарчимтай нийцэж байгаа эсэх нь өнөөдрийг хүртэл маргаантай байдаг.

Иймд энэхүү асуудлыг шийдвэрлэж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчимтай уялдуулах нь зүйтэй. Үүний тулд давж заалдах шатны шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалтыг өөрчилж, давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянахаар зохицуулж, хэргийг бүхэлд нь хянах зайлшгүй тохиолдлыг судлан хуульчлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах, зайлшгүй оролцох тохиолдлуудыг тодорхойлон хуульчлах. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд прокурор төрийн байгууллагын хүсэлтгүйгээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд оролцдог байх;

2. Давж заалдах шүүх хэргийг “бүхэлд нь хянадаг” үзэл баримтлалыг өөрчилж, хэргийг гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хянадаг үзэл баримтлалд шилжих, энэ талаар ИХШХШТХ-д өөрчлөлт оруулах, мөн давж заалдах шүүх хэргийг хянахдаа давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх тухай үзэл баримтлалыг судлах;

3. Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах зайлшгүй шаардлагатай тохиолдлыг судлан хуульд тусгайлан зааж өгөх. Тухайлбал, ЗХШХШТХ-ийн 118 дугаар зүйлд тусгасан байдлаар;

4. ИХШХШТХ-д цаашид зайлшгүй судлан үзэх шаардлагатай асуудлууд байх бөгөөд тэдгээрийг дэлгэрүүлэн судлан нь зүйтэй. Тухайлбал, хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, гуравдагч этгээдийн эрх зүйн байдал, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа гэх мэт.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
4. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
5. Прокурорын байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №29;

- 6.Прокурорын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №24;
- 7.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996, №11;
- 8.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол;
- 9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, УДШ-ийн 2002 оны 7 сарын 24-ний өдрийн 236 дугаар тогтоол;
- 10.УДШ-ийн 2009 оны 11 сарын 30-ны өдрийн 5 дугаар зөвлөмж, Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар;
- 11.Улсын Ерөнхий Прокурорын 2015 оны А/88 тоот дугаар тушаалаар батлагдсан Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар;
- 12.Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны А/62 тоот дугаар тушаалаар батлагдсан Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар.

Судалгааны тайлан, эмхэтгэл

- 1.Монгол Улсын шүүхийн тайлан /2017 он/, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он;

Ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл

- 1.Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд, 2013 он;
- 2.3.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, 2009 он;
- 3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, МУИС-ХЗС, 2011 он;
- 4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УДШ, 2007 он;
- 5.Юпп Ёоахимски, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, 2004 он;
- 6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /гарын авлага/, ХЗДХЯ, 2007 он;
- 7.Тушаал, заавар, журмын эмхэтгэл, УЕПГ, 2017 он;
- 8.Хууль дээдлэх ёс сэтгүүл, ХЗҮХ, 2016 он, №2;
- 9.Шүүх эрх мэдэл сэтгүүл, ШЕЗ, 2017 он, №3;
- 10.Монголын төр, эрх зүй сэтгүүл, УДШ, 2014 он, №2 (76);
- 11.Монголын төр, эрх зүй сэтгүүл, УДШ, 2018 он, №2 (91);
- 12.Эрх зүй сэтгүүл, МУИС-ХЗС, 2003 он, №10-11;
- 13.Эрх зүй сэтгүүл, МУИС-ХЗС, 2014 он, №4 (30).

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- 1.Н.Батзориг, Давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хянан үзэх хэмжээ хязгаар /гар бичмэлийн эрхтэй/, 2017 он.

Цахим эх сурвалж

- 1.<http://www.supremecourt.mn/act/view/65>
- 2.<http://www.judoinstitute.mn/main/233--2018-3-.html>

---oOo---